



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 514

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй 134,559,190.00 (нэг зуун гучин дөрвөн сая таван зуун тавин есөн мянга нэг зуун ерэн) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 4 ширхэг автомашиныг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ерөнхий захирал О.Доржсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002135

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн
514..... дугаар тогтоолын хавсралт



Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2018 оны 215, 216, дугаар тогтоолоор тогтоосон дуудлага худалдааны доод үнэ (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ (төгрөг)
1	Мазда бонго, 93-29 УБЛ, арал №SE28T300284	1996/ 2005	5,956,000.00	1,000,000.00	300,000.00
2	Хьюндай автобус, 49-32 УБЭ, арал №L4614413	2000/ 2000	95,877,000.00	1,000,000.00	300,000.00
3	Киа Оптима, 05-13 УБЭ, арал №30182	2001/ 2002	13,750,000.00	1,000,000.00	300,000.00
4	Мицубиши кантер, 86-97 УБК, арал№ FE51CB551356	1999/ 2010	18,976,190.00	6,200,000.00	1,000,000.00
	Нийт дүн		134,559,190.00 (нэг зуун гучин дөрвөн сая таван зуун тавин есөн мянга нэг зуун ерэн)	9,200,000.00 (есөн сая хоёр зуун мянган)	1,900,000.00 (нэг сая есөн зуун мянган)